



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/21

Амардалай

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.8, 32.1.9. дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.2.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22 -ний өдрийн 266 дугаар тогтоол "Хорио цээр, хязгаарлалтын дэглэм"-ийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ

1. Бог малын гоц халдварт мялзан өвчний голомт үүссэн Дэлгэр-Эмт, Баянбулаг багийн нутаг дэвсгэр  $46^{\circ} 3'52''107$   $N106^{\circ} 6'27''674$  солбицол Суварга,  $46^{\circ}13'48''1$   $N105^{\circ} 59'16''0$  солбицол Адаг ам,  $46^{\circ}14'05''7$   $N106^{\circ}07'52''0$  солбицол Цагаан хүйс газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 14 хоногийн хугацаатайгаар 98 километрийн радиуст хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Малын гоц халдварт мялзан өвчинтэй тэмцэх урьдчилсан сэргийлэх ажилд Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг сумын Шуурхай штабын дарга (С.Нарантунгалаг)-д даалгасугай.

3. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бус нутгийн малд үзлэг тандалт, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн нэгжийн эмч (М.Даваацэрэн, М.Ганьхүү) нарт үүрэг болгосугай.

4. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бус нутгийн хүн ам, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж хэв журам сахиулж ажиллахыг цагдаа (Б.Ууганбаатар) -т үүрэг болгосугай.

5. Малчид иргэд олон нийтэд малын гоц халдварт мялзан өвчний талаарх мэдээллийг хүргэж, урьдчилсан сэргийлэх сургалт гарын авлага, цахим мэдээллээр хүргэж ажиллахыг багийн Засаг дарга, Мал эмнэлгийн тасгийн дарга (Д.Наранцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай

ДАРГА  М.БАЯРСҮХ

